

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-20

-
- 1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлтийг хүлээн авсантай холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/** 4-17
18-19
- 2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Сонгон шалгаруулах комисс байгуулах тухай/** 17-18
19
- 3.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал** 19-20

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
04 дүгээр сарын 16-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 02 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Батбаатар;
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Л.Гантөмөр, Т.Доржханд, Л.Мөнхбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан, Н.Учрал, О.Цогтгэрэл, Ө.Шижир.

Нэг.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлтийг хүлээн авсантай холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Санадаг-Очир танилцуулав.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Ж.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ санал гаргасан боловч саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно. с сана саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, О.Номинчимэг, Ж.Баярмаа, Б.Баярбаатар, Г.Уянгахишиг, Ж.Бат-Эрдэнэ нар үг хэлж, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Сонгон шалгаруулах комисс байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлтийг хүлээн авсантай холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлгийг горимын санал хураалтаар үргэлжлүүлэн хэлэлцэв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 13 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны тогтоолын төсөл /Сонгон шалгаруулах комисс байгуулах тухай/-ийг санал хураалтаар үргэлжлүүлэн хэлэлцэв.

Ж.Бат-Эрдэнэ: “Сонгон шалгаруулах комисс байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5

Бүгд: 14
64.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатараас 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 13 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 06 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 08 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
12 цаг 02 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ингээд Байнгын хороонд оролцож байгаа гишүүдийн, хүрэлцэн ирсэн гишүүдийг танилцуулъя.

Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн байна. Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн байна. Сархадын Зулпхар гишүүн ирсэн. Эрдэнэбилигийн Одбаяр гишүүн ирсэн. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн ирсэн. Дашзэвэгийн Амарбаясгалан гишүүн ирсэн. Энхбатын Болормаа гишүүн ирсэн. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн. Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн. Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн. Нямтайширын Номтойбаяр гишүүн ирсэн. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн. Ингээд ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан анхны хэлэлцүүлэг.

Байнгын хорооны тогтоолын төсөл “Сонгон шалгаруулах комисс байгуулах тухай”,

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал гэсэн ийм 3 асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор асуулт асуух санал хэлэх гишүүд байна уу, саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Ингээд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд, хэлэлцэх асуудалдаа орьё.

Нэгдүгээр асуудал, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан анхны хэлэлцүүлгийг хэлэлцэнэ.

Ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулна. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Монгол Улсын үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг Арван зургаадугаар зүйлийн 9 дэх заалтын холбогдох зохицуулалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцээд 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдөр 03 дугаар дүгнэлт гаргасан.

Улсын Их Хурал уг дүгнэлтийг хэлэлцээд 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй гэж, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тэгш байдал, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш, эрх тэгш байна. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт хүнийг албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно, Арван зургаадугаар зүйлийн 9 дэх заалтад төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн тогтоолыг баталсан билээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84...-д дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол ажлын 15 өдрийн дотор тухайн болон холбогдох бусад хууль, шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна гэж. Мөн зүйлийн 84.5 дахь хэсэгт энэ хуулийн 84.3-д заасан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг холбогдох Байнгын хороо боловсруулж, нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд уг төслийн талаар Засгийн газар холбогдох бусад байгууллагаас санал авахыг шаардахгүй гэж заасан тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 3 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох хэсэгт зохих нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очиороор ахлуулан, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар, О.Номинчимэг, Г.Уянгахишиг, Ө.Шижир нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Ажлын хэсэг 3 удаа хуралдаж, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэг буюу Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаар нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй байх агуулгатай хэсгийг хүчингүй болсонд тооцох, мөн хуулийн 44

дүгээр зүйлийн 44.6 дахь хэсгийн Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчтой хийсэн уулзалт болон тус хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй байх зохицуулалтыг аливаа этгээд гэсэн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор зохион байгуулсан уулзалт болон тус хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй байхаар өөрчлөхөөр хуулийн төслийг боловсрууллаа.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх хэсэгт заасан ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал нөхөн ээлжит бус сонгуулийн тухайд сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал аливаа этгээд өөрөө болон бусдаар дамжуулж сонгогчдын саналыг татах зорилгоор эд зүйл тараахыг хориглосон зохицуулалтад ажлын хэвлэмэл тайлан хамаарахаар байна гэж үзэж тус хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсгийг хүчингүй болгохоор төсөлд тусгасан болно.

Тус хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалтад заасан эд зүйл тараах гэсэнд хийсэн ажлын цахим тайлан хамаарахгүй байна гэж ажлын хэсэг үзсэн болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 3 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгээс бэлтгэсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: Хуулийн төслийг та бүхэнд тараасан байгаа. Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн ажлын хэсгийн хуралдаанд оролцох ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя.

Б.Бат-Эрдэнэ ирсэн байна Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга.

Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна. Зулпхар гишүүн. Зулпхар гишүүний микрофон өгье. Зулпхар гишүүнээр тасаллаа.

С.Зулпхар: Та бүхний өдрийн амар амгаланг айлтган мэндчилье. Ажлын хэсгийн дарга Сандаг-Очир гишүүн ажлын хэсгийн гишүүдээс 1 асуулт, тодруулах зүйл байгаад байна.

Энэ Сонгуулийн тухай хуулийн 44.6-г энэ хуульд заасан нэр дэвшүүлэх үйл ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй гэдгийг Улсын Их Хурлын гишүүн гэдэг аливаа этгээд гээд ийм өргөжүүлсэн байдлаар эрхийг нь олгочихсон юм байна л даа. Тэгэхлээр яг саяынхаас өөр хувилбар та бүхэн ярилцсан уу гэдэг ийм нэг асуулт байна.

Хоёр дахь асуулт хэрвээ ингээд аливаа этгээд гээд ийм өргөн болгочих юм бол ерөөсөө сонгуулийн жил эхлээд л бид заримдаа хянаж болох уу агуулгынх нь хувьд хэлбэрийнх нь хувьд гэсэн үг шүү дээ. Энэ тийм сонгуулийн компани ажил эхэлж их ийм эрсдэл үүсэхгүй юу гэсэн ийм 2 асуулт байна.

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүн хариулъя.

Ц.Сандаг-Очир: Зулпхар гишүүний асуултад хариулъя. Тийм. үндсэндээ цэцийн дүгнэлт бол 2 агуулгатай байгаа 2 зүйл дээр. Нэг нь сонгуулийн жил эхэлснээс хойш нэр дэвшүүлэх ажиллагаа хүртэл Улсын Их Хурлын гишүүн хэвлэл материал, тайлан тарааж болох энэ заалт нь гишүүдэд давуу байдлыг олгосон байна гэж. Нөгөөдөх нь мөн адилхан хурал, уулзалт, цуглаан хийх нь бас зөвхөн гишүүдэд хамаатай байх нь Үндсэн хуулийн тэгш байх, мөн албан тушаалаар нь ялгаварлахгүй байх энэ заалтуудыг зөрчсөн гэж ингэсэн утгатай Цэцийн дүгнэлт гарсан.

Ингээд ажлын хэсэг бид бүхэн ярьж байгаад хэрвээ энэ бидний боловсруулсан хуулийн төсөл батлагдвал нэгд сонгуулийн жил эхэлснээс хойш нэр дэвшүүлэх ажиллагаа хүртэлх хугацаанд аливаа этгээдийг бид нар Улсын Их Хурлын гишүүн гэж байсныг аливаа этгээд болгосон. Аливаа этгээд гэхээр Улсын Их Хурлын гишүүн ч хамаарна, Засгийн газрын гишүүн ч хамаарна, бие даан жирийн иргэн ч хамаарна. Ерөөсөө Үндсэн хуулийн цэцийн агуулга болохоор хэн нэгэнд давуу байдлыг бий болгоод байна л гэж байгаа юм. Тэгэхээр бүгд сонгуулийг тэгш гараанаас, нолиос эрх тэгш байхын үүднээс бүгдэд уулзалт, хурал, цуглааныг бид нар нээж өгье. Ажлын тайлан ер нь бол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил. 4 жилийн хугацаанд бас гишүүд ажлаа тайлагнах, мөн бодлого төр засгийн бодлогыг шийдвэрлэх, танилцуулах ийм бас нэг талаар үүрэгтэй.

Тэгэхээр тэр салбарынхаа яамны ажлыг төр засгийн Их Хурлын хууль тогтоомжийг танилцуулах гээд байгаа бол тэр хурал, уулзалтаараа ярь. Зөвхөн Их Хурлын гишүүн нь ярьж болоод жирийн иргэн ярьж болохгүй, хаалттай байж болохгүй юм Үндсэн хуулийн цэцийн агуулга нь. Тэгэхээр бид нар аливаа тайлан, уулзалт, хурал цуглааныг сонгуулийн жил эхэлснээс хойш нэр дэвшүүлэх ажиллагаа хүртэл нээгээд өгье хуулийн этгээдэд. Хэвлэмэл материалыг болохоор сонгуулийн жил эхэлснээс хойш нэр дэвшүүлэх ажиллагаа хүртэлх хугацаанд хориглож байгаа. Хориглож байгаа юм. Яагаад гэхээр хэвлэмэл материал нэрийн доор Засгийн газрын гишүүд ажлын тайлангаа гэдэг нэрийн доор төсвийн санхүүжилтээр олон 100 хуудастай тайлан сэтгүүл гаргаад энэ нь өөрөө жирийн иргэдтэй харьцуулахад давуу байдлыг бий болгоод байна, далд сурталчилгаа явагдаад байна. Нөгөө талаар мөн Их Хурлын гишүүд мөн адилхан тайлан гээд нэрийн дор бас давуу байдлыг бий болгож аваад байна. Энэний цаана дандаа төсвийн мөнгө явж байгаа юм. Тийм учраас ер нь энэ.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүний минутыг нэмье.

Ц.Сандаг-Очир: Тэгэхээр ерөөсөө агуулга нь хэвлэл материалыг сонгуулийн жил эхэлснээс хойш бүгдэд хаалттай, уулзалт, хурал, цуглааныг нээлттэй. Нөгөө талаар цахимаар ажлын тайлан, тэр салбарын тайлангаа тавиад танилцуулаад, тайлагнаад явах нь нээлттэй байдлаар бид нар ингэж оруулж өгснөөрөө ер нь бүгд төсвийг аль болох, сонгуулийг аль болох шударга, нээлттэй, бүгд эрх тэгш байх, төсвийг бас үр ашигтай хэмнэх, бага төсвөөр сонгуулийг

явуулдаг байх ийм Үндсэн хуулийн агуулга ч хангагдаж байна. Нөгөө талаар Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргасан иргэдийн ч гомдол бас хангагдахаар. Ийм учраас бид нар аль аль талыг харж энэ хуулийн төслийг боловсруулсан.

Ж.Бат-Эрдэнэ: Би 1 асуулт асууя. Бас л ерөнхийдөө зорилго нь Зулпхар гишүүнтэй бараг л ойролцоо. Сандаг-Очир гишүүн, энэ ажлын хэсгийнхэнд хандаад энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө аливаа этгээд гээд байгаа юм хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор, хийсэн ажлын танилцуулга гээд жишээ нь бие даагч орж ирвэл бие даагчийнхаа бизнес байдаг юм уу, юу байдаг юм, энэ үйл ажиллагаагаа л танилцуулах гээд байна шүү дээ. Тэгэхээр бид өрсөлдөөнийг бий болгоно, цэвэр сонгогчид сонгох боломж бололцоог нь хангах 1 өнцгөөс, 1 гараанаас эхлэх ийм боломж, бололцоог нь нээгээд байгаа шүү дээ. Тэгэхээр аливаа этгээд гэдэг дээр бүх хүмүүс орчхоод байна тийм үү? Бүх хүмүүс орчхоод байна. Тэгэхээр тэр өөрсдийнхөө үйл ажиллагааг танилцуулах, энэ боломж бололцоо чинь нээлттэй болчихоод байна гэсэн үг үү тийм үү? Энэ дээр арай л жоохон авмаар байх юм тодорхой хариултуудыг өшөө жоохон тодруулж өгөөч. Гол лок нь яг юун дээр байна? Хэн хариулах вэ? Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Харин тийм. Зулпхар гишүүн бас яг тантай адилхан саналыг хэлсэн. Аливаа этгээд гэж бид нар өөрчилсөн. Аливаа этгээдэд сонгуулийн жил эхэлснээс хойш болоод нэр дэвшүүлэх ажиллагаа хүртэл хугацаанд тэр бизнесийн уулзалтаа хийнэ үү, тодорхой орон нутгийн тодорхой асуудал хөндсөн сэдвээр уулзалт, ярилцлага хийнэ үү энэ бол нээлттэй. Одоо ч хуулиараа, одоо ч мөрдөгдөж байгаа хуулиараа энэ нээлттэй байгаа. Хориглосон зүйл байхгүй байгаа. Гагцхүү Үндсэн хуулийн цэц юу гэж үзсэн бэ гэхээр Улсын Их Хурлын гишүүнд тайлан хэвлэж болно. Энэ нь Улсын Их Хурлын гишүүнд хамаарахгүй. Уулзалт хийх нь бас Улсын Их Хурлын гишүүнд хамаарахгүй гэдэг ийм заалт л байсан шүү дээ. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүн гэдэг хүнд аливаа давуу байдлыг бий болгоод байсан гэж үзэж байгаа юм. Тэгэхээр нөгөө Үндсэн хуулийн тэгш байх зарчим, нөгөө албан тушаалаар нь ялгаварлахгүй байх зарчмууд хөндөгдөөд байна гэж Цэцийн дүгнэлт үзсэн.

Тийм учраас бид нар аливаа этгээд Улсын Их Хурлын гишүүн гэж онцлохгүйгээр сонгуулийн жил эхэлснээс хойш нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэх хүртэл хугацаанд уулзалт, хурал, цуглаан хийх аливаа асуудлаар төр засгийн болоод хийсэн ажлын тайлангаа ярих эрхийг нь нээгээд өгчихье. Энэ чинь нөгөө талаасаа бас үүрэгтэй энэ тодорхой албан тушаалтнуудад, орон нутгийн удирдлагуудад, Засгийн газрын гишүүдэд, Их Хурлын гишүүдэд, бас жирийн иргэдэд, бизнес эрхлэгчдэд тодорхой асуудлаар тодорхой орон нутгийн иргэдэд уулзалт хийх эрхийг нь нээлттэй, одоо ч нээлттэй байгаа. Бид нар цаашдаа ч энийг нь Их Хурлын гишүүдэд давуу байдлыг бий болгоод өгөх асуудлыг заавал ингэж Их Хурлын гишүүн гэхгүйгээр аливаа этгээд гээд оруулаад өгчихье. Ингэвэл бид нар бүгдээрээ Их Хурлын гишүүн байна уу, Засгийн газрын гишүүн байна уу, жирийн иргэн хэн байна, тэр уулзалт, хурал, цуглаанаа орон нутагт баг хороон дээр очоод хийх эрхийг нь нээгээд өгье.

Харин хэвлэмэл материал тараахыг нь бүх этгээдэд энэ нь өөрөө 48-ынхаа 1.1 дээр эд зүйл гэдэг дотор хэвлэмэл материал чинь ороод байгаа юм өргөн утгаараа эд зүйл гэдэг дотор. Тэгэхээр энийг нь хаагаад өгчихье. Цахимаар бол нээлттэй гэсэн ийм л хуулийн төслийг бид нар боловсруулсан. Тэгээд энэ дээр бас

сонгуулийн хорооны Бат-Эрдэнэ дарга, Тамгын дарга Бат-Эрдэнэ дарга бас тодорхой Бат-Эрдэнэ гишүүний асуултад бас нэмж тайлбар хийгээд өг.

Ж.Бат-Эрдэнэ: Би тодруулаадахъя. Тодруулаад асуугаадахъя. Наад хугацааны чинь хүрээнд өөрөөр хэлбэл сонгуулийн жил эхэллээ гэдгээс эхлээд аливаа этгээд бүгдээрээ оролцоно гэж байгаа бол сонгуулийн сурталчилгааны хугацаа чинь суначхаж байгаатай адилхан болно. Сонгуулийн сурталчилгааны ажил чинь сунгачхаж байгаатай адилхан болно. Бүгд оролцох байхгүй юу. Бүгд үйл ажиллагаа юмаа танилцуулъя. Гэтэл бид нар сонгуулийн сурталчилгаа эхлэх хугацаа гэж тусдаа хугацаа байж байгаа шүү дээ. Эсвэл Улсын Их Хурлын гишүүн тодорхой яг сонгуулийн жил эхлэнгүүт л юмаа тараахаа больчихъё л доо. Тэр хүртэл үйл ажиллагаагаа танилцуулаад явна биз. Болно шүү дээ. Тэртээ тэргүй цаана сонгуулийн сурталчилгаа хийх хугацаа чинь цаана чинь заалттай байна шүү дээ хуулиар. Тэндээ тэгвэл бүгдээрээ хийцгээе л дээ. Нэг ийм юу байх юм энэ дээр тайлбар хэлж өгөөч.

Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Сонгуулийн сурталчилгаа хийх хугацаа нэг талаар сунгаж байгаа юм шиг харагдаж байгаа боловч үгүй юм. Сонгуулийн сурталчилгаа гэдэг тэр хурал, уулзалт, цуглаан хийх эрхийг нь нээж байгаа боловч тэр уулзалт хурал хийж байгаа аливаа этгээд ямар сонгуулийн сурталчилгаатай холбоотой өөрийгөө сурталчлаад би дэвших гэж байгаа юм, намайг дэмжээрэй гэдэг ийм асуудал энэ уулзалт, хурал, цуглаанд бол байж болохгүй. Энэ бол хориотой. Сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш уулзалт, хурал хийчих юм бол би энэ удаагийн сонгуульд бие дааж байгаа юм, би энэ намаас дэвшиж байгаа юм гээд яриад явах нь нээлттэй. Гагцхүү 1 сарын 1-нээс сонгуулийн жил эхэлснээс хойш нэр дэвшүүлэх ажил хүртэл хугацаанд хийж байгаа хурал, уулзалт, цуглаан бол тодорхой л төрийн, төр засгийн ажил болоод бизнесийн үйл ажиллагаа тодорхой асуудлуудаараа л ярих нь нээлттэй боловч тэр дээр би дэвших гэж байгаа юм шүү, намайг дэмжээрэй, би ингэх гэж байгаа юм шүү гэдэг ийм асуудал ярих нь хориотой шүү. Тийм, ялгаа нь бол энэ. Энэ дээр Бат-Эрдэнэ дарга бас тайлбар өгөх үү?

Ж.Бат-Эрдэнэ: Бат-Эрдэнэ Ажлын хэсгийн ажлын хэсэг 3 номер нэрээ хэлээд танилцуулаарай.

Д.Бат-Эрдэнэ: Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Бат-Эрдэнэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд тэгш боломжийг олгохгүй байгаа нь өөрөө Үндсэн хууль зөрчиж байна гэдэг гол агуулга байгаад байгаа. Яг үүнтэйгээ холбоотойгоор дэлхийн бусад улс оронд 3 төрлийн арга хэлбэр байна. Нэгдүгээрт бол бүгдийг нь нээлттэй орхичхож байна. Иргэн ч бай, Их Хурлын гишүүн ч бай ямар нэгэн хугацаа хязгаарлалтгүйгээр тайлангаа тавьдаг ийм боломж байна.

2 дугаар хувилбар бол тодорхой хугацаа зааж өгдөг байна. 3 дахь хувилбар нь бол зөвхөн гишүүд гэдэг юм уу, эрх бүхий этгээд л тайлангаа танилцуулна. Гэтэл Монгол Улсын хувьд бол эрх хязгаарлахдаа хамгийн тохиромжтой хувилбарыг сонгоогүй юм байна энийг хараач л гэдэг ийм дүгнэлт байсан.

Тэгээд энд бол Их Хурлын гишүүн энэ хуулийн заалтыг хэрвээ тэр чигт нь хүчингүй болгоно гэх юм бол Их Хурлын гишүүд Их Хурлын тухай хуулиараа

тайлангаа аль ч цаг хугацаанд танилцуулах бүрэн эрх нь байгаа учраас тодорхой тэгш боломжийг олгох үүднээс иргэдэд бас энэ боломжийг олгоё. Их Хурлын гишүүн биш ч гэсэн бусад хүмүүс ч гэсэн зөвхөн хийж хэрэгжүүлсэн ажлын тайлангаа мөн адилхан уулзалт хэлбэрээр ингээд танилцуулаад явах энэ боломжийг нь адилхан болгож өгье. Ингэснээр Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд илүү бас дөхөх хамгийн боломжит хувилбар энэ юм байна гэж ингэж бол үзсэн байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа.

Одоо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Би саналтай байна.

Энэ өөрөөр хэлбэл бид нарын сонгуулийн хугацаат, хугацаа эхэлтэл аливаа этгээд буюу Улсын Их Хурлын гишүүн ч бай, хэн ч бай үгээ хэлээд л явуулж байгаа, уулзалтаа хийгээд л явж байгаа. Иргэдтэйгээ уулзалт хийгээд л явж байгаа шүү дээ. Яагаад сонгуулийн жил эхэлтэл, эхлэх энэ хугацааг ингэж тодорхой хэмжээнд ингэж авч байгаа юм. Тодруулж авч байгаа юм? Энэ өөрөө авч байна гэдэг чинь энэ чинь сурталчилгаа хийх тодорхой хугацааны өмнө хүн өөрийгөө танилцуулахгүй байх, сурталчилгаа эхлэхгүй байх гээд ингээд тодорхой хугацааг бол цаана чинь зааж өгч байгаа шүү дээ сурталчилгаа хийх хугацаа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт та бүхний ярьж байгаа наад тайлан гэж байгаа шүү дээ. Үгүй яах вэ өөрийгөө сурталчлахад намайг сонгоорой гэж хэлэхгүй гэж байгаа байхгүй юу даа. Тэгвэл хэлчихвэл яах юм? Яг ямар арга хэмжээ авах юм? Амьдрал дээр хэлж болдог шүү дээ. Хэлээд л явдаг шүү дээ. Би сонгуульд оролцож байгаа гэдэг ийм зүйлийг энд тэнд ингээд уулзалт хийгээд явуулаад л байдаг шүү дээ. Тэгэхээр бид нар нэгэнт хуульд өөрчлөлт оруулж байгаа бол энийг хаасан зүйлээ давхар оруулах хэрэгтэй. Хэлчихвэл яах юм? Эсвэл хуулиар заасан сурталчилгаа гэдэг асуудал байж байгаа бол тэндээ л сурталчилгаагаа л хийцгээе. Ийм л санал байгаа. Тэгэхээр энийг яг үнэндээ бол саналыг бол жишээ нь аливаа этгээд гэдэг дээр бас магадгүй зүгээр 44.6 дугаар зүйл дээр дахиад нэмэлт тодруулгатайгаар, заалттайгаар оруулах ч байдаг юм уу ийм л санал байх юм. Ажлын хэсэг энийгээ яаж авч хэлэлцэх юм бол? Уг нь бол саналаа томъёолж орох ёстой тээ?

Томъёолсон санал байхгүй тул саналаа татлаа. Энэ дээр саналтай гишүүд байхгүй байна тээ?

Хоёрдугаарт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

1 гишүүн байна. Зулпхар гишүүн. Зулпхар гишүүнээр. Өөр хүн, өөр гишүүд алга байна. Зулпхар гишүүнээр тасалъя. Зулпхар гишүүний микрофоныг өгье.

С.Зулпхар: Энэ их тийм бас жоохон нарийн ээдрээтэй л асуудал болчихлоо. Гэхдээ нөгөө талдаа уг нь их тодорхой зүйл юм л гэж ойлгож байгаа

шүү дээ. Аливаа Улсын Их Хурлын гишүүнд олгосон эрх бол талаар тухайн институтэд буюу хууль тогтоох засаглалд парламентад өөрт нь олгосон чиг үүрэгтэй нь уялдуулж олгосон эрх гэж ойлгож байгаа юм. Тэгээд энийг бол Үндсэн хуулиар тодорхойлчихсон, Улсын Их Хурлын тухай хуулиар тодорхойлчихсон байгаа. Жишээ нь Үндсэн хууль дээр Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр эхлээд, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүн тангараг өргөснөөр дуусгавар болно гээд яг 4 жилийн хугацаанд Улсын Их Хуралд хүлээсэн бүрэн эрхээ буюу чиг үүргээ хэрэгжүүлнэ гээд ингээд заачихсан байгаа юм. Тэгэхээр сонгуулийн жил эхэлсэн байлаа ч гэсэн ямар нэгэн байдлаар өөрийнхөө чиг үүргийн дагуу ажлаа тайлагнах, танилцуулах, уулзалт цуглаан хийх эрх нь Үндсэн хуулиар нээлттэй байж байгаа байхгүй юу, байх ёстой чиг үүргийнх нь хувьд.

Хоёрдугаарт энийг Улсын Их Хурлын тухай хуулиар мөн адил гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байна гээд 7.3-аар заачихсан байгаа. Цаашлаад 8 дугаар зүйлийн 8.1.26-д гишүүний бүрэн эрх гэдэг дээр сонгогчдод үйл ажиллагаа мэдээлэх гээд эрх нь байж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид энэ бол гишүүн бол Үндсэн хуулиар ч тэр, Улсын Их Хурлын тухай хуулиар ч тэр иргэдэд мэдээлэх үүргээ бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлэх ёстой юм байгаа юм. Тэгэхээр бид анхнаасаа энэ Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлтийг хүлээгээд авчихдаг нь бол анхандаа бас их эргэлзээтэй асуудал болчихсон. Тэгэхдээ энийг нэгэнт Их Хурал шийдвэр гаргачихсан учраас бид нар тэрийг хэлэлцэх эрх байхгүй. Яг энэтэй уялдсан байдлаар 44.6-г харин бид нар гишүүний болон Улсын Их Хурлын институтийнх нь хувьд бол чиг үүргээ хэрэгжүүлэхтэй уялдсан байдлаар энийг боловсруулах нь зүйтэй байх гэж бодож байна.

Аливаа этгээд гээд өргөжүүлчхээрэй зэрэг бид Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авч байгаа юм шиг мөртөө нөгөө талдаа тэртээ тэргүй энэ 44.6 чинь анх бол Улсын Их Хурлын гишүүний тухайд өөрийнх нь эрхийг нь зохицуулсан Сонгуулийн тухай хуулийн тодорхой заалт байхгүй юу. Тэгсэн чинь энэ их хурлын тухай гишүүний тодорхой заалт биш бүх иргэдийн хуулийн этгээдийн тухайд ийм заалт болоод өөрчлөгдчихлөө гэж байгаа юм. Тэгэхлээр энийг хэдүүлээ ахиад сайн нарийн бодож, хууль зүйн талаас нь, тэрнээс гадна саяын холбогдох хуулиудаа уялдсан байдлаас нь авч үзэх ёстой байгаа юм. Хэрвээ энийг ингээд тавьчих юм бол хэрвээ ингээгүй нөхцөлд бол бараг буцаад энэ чинь Үндсэн хуулийн цэц дээр маргаан үүсгэж болохоор юм байдал руу ч орж магадгүй гэж байгаа юм.

Тэгэхлээр энийг ажлын хэсгийнхэн маань ахиад жишээ нь бодооч гэсэн үүднээс би бол энэ дээр бол өнөөдөр бид энэ яг дөр 44.6 дээр бол дахин боловсруулах байдлаар энийг дараа нь жишээ нь ахиж хэлэлцэх байдлаар авч үзвэл яасан юм бэ гэсэн ийм саналтай байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Энэ маргаан дээр би бас итгэмжилсэн төлөөлөгчөөр орсон. Тэгээд Улсын Их Хурал дээр ч гэсэн үг хэлэхдээ Цэц бол энэ нөгөө заалтуудыг дөрвөн үндэслэлтэй дөрвүүлэнгээр нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн. Гэхдээ бид нар хүлээж авахдаа зөвхөн нэг үндэслэлээр нь хүлээж авах ёстой?. Нөгөө гурван үндэслэлээр хүлээж авах ёсгүй гэдгийг байр суурь тэр үед илэрхийлсэн боловчиг ирцийн асуудал байсан уу, юу байсан уу дөрвөн үндэслэлээр нь бүгдийг нь хүлээгээд авчихсан, Улсын Их Хурал маань тогтоолоо тэгээд гаргачихсан.

Тэгэхээр нөгөө эрх тэгш байдал, энэ ойлгомжгүй хууль тогтоомж нь ойлгомжгүй байдал гэдэг энэ асуудлыг нь Улсын Их Хурал маань хүлээгээд авчихсан учраас бид хүлээж авсан хүрээндээ энэ ажлын хэсэг ажиллаад ийм асуудал гарч байгаа. Яг үнэнийг хэлэхэд бас Бат-Эрдэнэ даргатай бол нэг санал байна. Энийг ингэж нээснээрээ бид нар нөгөө сонгуулийн сурталчилгаа гэдгийн хугацаа чинь яг ямар болох вэ, тэгээд энэнтэй холбогдоод бид нарын дандаа ярьдаг нөгөө сонгууль болон сонгуулийн сурталчилгааг зардалгүй явуулъя, нүсэр байлгах аа больё гэдэг юм маань эвдэгдэх вий дээ гэдэг үнэхээр санаа зовнил байгаа. Яах вэ ажлын хэсэг дээр бол мэдээж Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хүрээнд уулзалтаа хийх нь зөв. Тайлангийн хувьд эд бараа буюу том зузаан сэтгүүл тарааж байгаа нь өөрөө яг тайлан, ажлын тайлагналаа хийнэ гэхээсээ илүү төсвийн мөнгөөр сурталчилгааны материал чиглэл рүүгээ явж байгаа байдал нь их байгаа учраас тухайн үед бол цахим тайлангаараа ингээд хүргүүлдэг больё, уулзалтаараа энэ бүхнийгээ бас тайлбарлачихдаггүй, юм тараахаа больё гэдэг дээр санал нэгдэж байгаа. Зүгээр энэ маань нөгөө утгаараа Бат-Эрдэнэ Сонгуулийн ерөнхий хорооны дарга ч гэсэн тухайн үед тайлбарлаж байсан. Энэ энгийн иргэд тэр хориглосон сурталчилгааны зүйлийг харах юм бол уулзалт гэж ерөөсөө байхгүй, нээлттэй байгаа шүү дээ гэдэг юмыг хэлж байсан боловч Цэц өөрөө яг нээлттэй байгаа юм уу, үгүй юм уу гэдэг чинь ойлгомжгүй байна гэдэг юм гаргачихсан юм.

Би бол тэн дээр бол итгэмжилсэн төлөөлөгчийн хувьд бол санал нийлэхгүй ойлгомжтой. Энэ бол өөр субъектээр Улсын Их Хурлын гишүүн бол бүрэн эрх буюу үүрэгтэй байхгүй юу тайлагнах. Энийг бас ингэж хамтад нь үзэх шаардлагагүй гэсэн боловч нөгөө хүлээж авах үндэслэлээ бид нар бүүр бүрэн зөвшөөрчхөнгүүт ялт ч үгүй ойлгомжтой болох чиглэл рүү иймэрхүү томьёолол олж авч тавиад ажлын хэсгээс ийм санал гарсан байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ. Хэлье хэлье Баярмаа гишүүн. Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Энэ нөгөө дахин боловсруулалтад өгөх хугацаа нь дуусчихсан маягийн юм байна шүү дээ тээ? Зарчмын хувьд энэ яг зөв л дөө. Нөгөө л бид нарын яриад байдаг хувь хүн, хувь нэр дэвшигч элдэв төрлийн юм тараах барих категориос гадна төрийн хүч нөөцийг ашиглаж элдэв төрлийн юм тараах буюу давуу байдал ашиглаад байгаа гэдэг тэр зарчим дотор хамаарч байгаа байх. Яагаад гэвэл улсын мөнгөөр тэр тайлан хийж тарааж байгаа гэдгээр болбол.

Тэгэхээр нөгөө талдаа бас зөвхөн Улсын Их Хурлын гишүүдийг хориглоод орхичихоор цаана нь сайд нар хүртэл сайд байхдаа хүртэл тайлан тарааж байсан шүү дээ иргэдэд хаа хамаагүй. Тэр сайд хүн бол иргэдийн өмнө яг тайлагнах хуулийн үүрэгтэй байсан эсэхийг мэдэхгүй боловч ингээд тараагаад явчихдаг. Тэгэхээр эсрэгээрээ Улсын Их Хурлын гишүүд нь төлөөлж байгаа утгаараа тайлагнах ёстой атал тэр эрх нь байхгүй болсон мөртөө сайд нарт ч юм уу, бусад бизнес эрхлэгч, дэвшихийг санаархаж байгаа аливаа этгээдүүдэд нээлттэй орхиж бас болохгүй нөгөө ижил гараа гэдэг утгаараа.

Тэгэхээр аливаа, энэ ер нь маш хэцүү л юм байна лээ. Нөгөө потенциал кандидат гэдэг хүмүүсийг бид нар яаж тодорхойлох вэ гэдэг чинь асар хэцүү учраас яг энэ аливаа этгээд гээд л одоохондоо оруулаад явахаас өөр замгүй юм байна лээ. Тэгээд энэ чинь зөндөө л юм болох байх. Бид нар энэ дээр өшөө нарийн ажиллаад, өшөө бусад зөвхөн тайлан төдийгүй нөгөө сонгуулийн бус үеийн

юмнуудыг нь яах вэ гээд бид нарын өмнө маш том сорилт байгаа. Тэгэхээр энийг ямар ч байсан өнөөдөртөө бид боломжийнхоо хэмжээнд яг энэ хүрээнд нь ингэж томъёолох зөв гэж харж байгаа. Зүгээр яах вэ найруулгын хувьд ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчдын санал татах зорилгоор гээд нэг өгүүлбэрт ийм хоёр зорилгоор энэ тэр гэж яваад жоохон найруулга зүйн хувьд тиймэрхүү юм уу л гэж харагдлаа.

Хоёрт, ер нь зарчмын хувьд нэг юм хэлэхэд ийм юм байна лээ. Би энэ дээр чинь ажиллаад судалгаанууд хийгээд байгаа юм. Сонгогчдын санал татах зорилгоор гэдэг үг өөрөө их эвгүй үг байдаг юм байна. Яг шүүх дээр очихоор яг сонгогчдын саналыг татах эсэхийг нь тодорхойлоход, тогтооход хэцүү болчихдог юм байна. Энэ барууны орны туршлагаудыг харахаар. Үгүй би татах зорилго агуулаагүй гээд л дайраад байвал агуулсан гээд байх хэцүү. Тэгэхээр хойшид бид нар ер нь энэ сонгогчдын санал татах зорилгоор гэдэг үгийг бүүр авч хаямаар юм байна лээ. Ерөөсөө л болохгүй. Тэр ямар зорилготой байх нь хамаагүй. Улсын Их Хурлын гишүүн буюу сайд нар тэр сүүлийн 6 сар тайлан тараахгүй всё. Тэгэхгүй болохоор үгүй энэ зорилгыг нь нотол л доо гээд ингээд шүүхдээд явах цагт бол бас унах юм байдаг юм байна лээ энэ сүүлийн хэдэн сар энэ асуудлаар судалгаа хийж байх явцад.

Тэгэхээр магадгүй энэ татах зорилгоор гэдэг үгийг авч хаяж болох эсэхийг нь би мэдэхгүй байна. Яг өнөөдөр хүртэл энэ ямар процесс явагдсаныг мэдээгүй учраас. Тэгэхээр энэ үгнээс бас болгоомжилмоор.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийн нэг зүйлийг хэлье. Энэ хугацаа өөрөөр хэлбэл 1 сарын 1-нээс эхэлчихдэг байх тээ сонгуулийн хугацаа? Энэнээс эхлээд буум болно шүү. Мөнгөтэй төгрөгтэй хүн болгон машин тэргээ хөллөөд уулзалт хийгээд, тайлангаа тавиад ингээд явдаг хүн болно шүү. Нөгөө сонгуулийн зардал гэдэг юман дээр хэн мөнгөтэй, хэн боломжтой нь илүү тэр тайлангаа танилцуулж байна гэж хөдөөгөөр хэрдэг, мөнгө төгрөгөөрөө илүү давуу эрх эдэлдэг ийм байдлаа дэвэргэж байна шүү. Яг үнэндээ бол. Сонгуульд орох тэгш эрхийг хангаж байгаа бус эсрэгээрээ хэн бололцоотой нь илүү их давуу эрх эдлүүлж байгаа. Өөрөөр хэлбэл, нөгөө мөнгөтэй төгрөгтэй хүмүүс нь илүү сонгуульд оролцох, илүү ажлаа танилцуулдаг, илүү давхидаг, илүү юмаа зардаг ийм боломжийг нь нээж байгаа юм байна шүү.

Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Энэ 44.6-г ер нь дэмжих боломжгүй л байгаад байгаа юм. Яах вэ Үндсэн хууль зөрчсөн байсан гээд ер нь энэ өнгөрсөн хугацаанд чинь тэгээд мөрдөгдөж байсан заалтууд тэгээд л Үндсэн хууль зөрчсөн болж гарч ирээд л ингээд л аливаа хууль, эрх зүйн тийм мухардалд аваачаад л байгаа юм л даа. Тэгээд аливаа этгээд гэдгээ бид нар ер нь яг эрх зүйн талаас нь яг юу гэж тайлбарлах юм? Тэгээд энэний чинь цаана тэгээд л саяын Баярмаа гишүүний хэлдгээр тэр хариуцлагын асуудал нь яах юм? Тэгээд энэ чинь тэгээд хавтгайдаа л юм болно шүү дээ ер нь. Бараг ингээд нөгөө өмнөх заалтаасаа дордуулсан хэлбэр рүү л орж ирж байгаа юм болов уу л гэж л би хараад байгаа юм.

Тэгэхээр энийг миний хувь зүгээсээ харахад дэмжих боломж харагдахгүй л байна. Тийм. Сонгуулийн жил гэдэг чинь өөрөө чухал цаг хугацаа л даа. Сонгуулийн жил чинь өөрөө чухал цаг хугацаа байхгүй юу. Тэгээд үгүй үгүй хэн ч

явахгүй шүү дээ. Өнөөдөр мөнгө төгрөгөө үрээд хэн ч явахгүй байхгүй юу. Өнөөдрийн явсан юм жилийн дараа мартагдах учраас хэн ч явахгүй шүү дээ. Сонгуулийн жил гэдгээ сайн тооцоолоод тэгээд тэр үед чинь тэгээд л жишээлбэл, Улсын Их Хурлын гишүүд эндээ чуулган, Байнгын хороо гээд ингээд байж л. Тэгтэл тэнд аливаа этгээд гэдэг товч орсон нөхөр бол тэр орон нутагт очоод уулзалт, цуглаан хийгээд явна шүү дээ. Тэгээд тэн дээр чинь очоод хэнийг ярих юм? Энэ парламентыг л муулдаг шүү дээ ер нь бол. Яг энд сууж байгаа нөхдүүдийг чинь л муулаад л, энэ Засгийн газрыг чинь шүүмжлээд л, попроод л явдаг л тийм л цаг үеийн тэр сонгуулийн жилдээ орчхож байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг дэмжих боломжгүй гэсэн байр суурь илэрхийлж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Жоохон хэлэлцээдэхье хэлэлцээдэхье, ярьчихъя.

Уянгахишиг гишүүн, Баярмаа гишүүнд дараа нь. Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Энэ дээр ийм асуудал үүсээд байгаа юм. Яг 44.6-гаар болохоор байсан заалт нь ер нь бол Улсын Их Хурлын гишүүн нөгөө бусад хуулиараа буюу түрүүний Зулпхар гишүүний хэлсэнчлэн Их Хурлын тухай хууль болон Үндсэн хуулиараа дараагийн парламент эхэлтэл буюу бүрэн эрх дуустлаа нөгөө ажлын тайлангаа тавих, уулзалт хийх эрх нь нээлттэй байгаад байгаа байхгүй юу.

Тэгэнгүүт 44.6 дугаар заалтын зорилго нь юу вэ гэхээр нэр дэвшүүлэх ажиллагаа эхэлчих юм бол Улсын Их Хурлын гишүүн тэр уулзалтаа хийж болохгүй гэдэг агуулгатай байхгүй юу. Өөрөөр хэлбэл, нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө ажлын тайлангаа танилцуулах, уулзалтуудыг хийх нь энд хамаарахгүй гэдэг маань нөгөө цохож татаж авчирсан заалт гэсэн үг.

Хэрвээ энэ заалт байхгүй болчих юм бол нэр дэвшүүлэх ажиллагаа эхэлчихсэний дараа ч гэсэн Их Хурлын гишүүн тайлангаа, нөгөө ажлын тайлангаа танилцуулах уулзалтыг хийж болох гээд байгаа байхгүй юу. Энэ нь өөрөө цаад утга нь гэхээр жишээлбэл, сонгуулийн сурталчилгааг төсвийн мөнгөөр хийх боломжтой болчихоод байна гэсэн үг. Тэгэхээр энэ утгаараа энэ заалт орсон байсан. Тэгэнгүүт энэ нь өөрөө юу байна зөвхөн Улсын Их Хурлын гишүүний онцгой эрх болгож оруулж байгаа юм шиг заалт болчихоод байна гэдэг байдлаар Үндсэн хуулийн цэц дээр тайлбарлагдсан учраас хэрвээ бид нар өнөөдрийн ярьж байгаа сая зардал хэмнэх, сонгуулийн сурталчилгааг, сонгуулийн жил эхэлснээс хойш нэр дэвшүүлэх ажиллагаа хүртэл ямарваа уулзалт, цуглаан хийх энэ өөрөө сонгуульд нөлөөлнө гэж үзэж байгаа бол, сонгуулийн зардлыг ихэсгэх хэмжээнд нөлөөлнө гэж үзэж байгаа бол ерөөсөө сонгуулийн жил эхэлснээс хойш хэн ч ямар ч уулзалт, цуглаан хийхгүй байх гэдгээр хориглох буюу Улсын Их Хурлын гишүүн ерөөсөө нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэх биш, бүүр сонгуулийн жил эхлэхээс эхлээд ямар нэг уулзалт, цуглаан, ажлаа тайлан тавьж байна гэдэг уулзалт хийхгүй байхаар тийм зохицуулалтыг оруулах боломж бий.

Тэгэхээр энэ дээр бол бид нарын гаргах гол юм гишүүдээс гол нь яг аль утгаараа хэрэгжүүлэхээр байна вэ алин дээр санал нэгдэх вэ гэдэг л асуудал байгаа гэсэн үг. Хэрвээ Бат-Эрдэнэ даргын хэлж байгаачлан ерөөсөө сонгуулийн жил эхэлснээс хойш янз бүрийн тэгж мөнгө төгрөг үрж, уулзалт, цуглаан хийдгийг болиулья гэж байгаа бол тийм байдлаар томъёолж оруулах бүрэн боломжтой. Тэгэхээр тэр нь сайд нар, төрийн, улс төрийн албан хаагчид бүгд хамаарч орж

болох байхгүй юу. Тэгэхгүй зөвхөн Их хурлын гишүүнээр хязгаарлахгүйгээр сайд нар ч гэсэн ажлын тайлангаа тавиад явдаг.

Гэтэл нөгөө талаасаа ажлын хэсэг дээр бид нар яг энийг ярилцаад тэгэнгүүт тэгвэл одоо нөгөө хуулиар хүлээсэн үүрэг нь яах вэ? Нөгөө сайд нар нөгөө ажлын тайлангаа тавих ёстой, яамны хийсэн ажлаа тайлагнах.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Нэг бол Их Хурлын гишүүн, бусад нэр дэвшигч, сайд нар гээд яах вэ гурван субъект гэж авч үзэхэд гурвууланд нь тэгш боломж байх ёстой гэдэг үндсэн зорилго байгаа юм. Тэгэхээр гурвууланд нь зөвхөн Их Хурлын гишүүд эрх авахын тулд тэгвэл бүүр энэ уулзалтыг нь ч хүртэл больё гэж бас болохгүй болж байгаа байхгүй юу. Тэгээд ийм болохгүй. Тэгэнгүүт чинь уулзалтаа нээлттэй болгоё гэхээр зөвхөн Их Хурлын гишүүд уулзаж бас болохгүй. Энэ чинь жинхэнэ нөгөө Үндсэн хуулийн зөрчил. Тэгэхээр дахиад аливаа зүйлийг хориглоно гэдэг чинь угаасаа утгагүй. Энэ чинь хэн ч, хаана ч, ямар ч төрлийн уулзалт хийгээд хэнийгээ ч шүүмжлээд явж байх бүрэн эрхтэй. Тэгэхээр Их Хурлын гишүүд биднийг ингээд шүүмжлээд муулаад явдаг тэрийг нь болиулах гэж байгаа гэж яривал энэ чинь маш буруу, маш эвгүй өнцөг болно. Уулзалттай, уулзалтгүй муулахдаа тулбал муулна. Тэгэхээр аливаа юмыг хориглох, хаах биш нээ, боломжийг нь олго.

Гэхдээ Их Хурлын гишүүд нь ч гэсэн очоод уулзалтаа ч хий, бусдууд нь ч хий, бүгдэд нь энэ тайланг нь хаая. Зөвхөн Их Хурлын гишүүдэд бас хааж болохгүй болчхож байгаа байхгүй юу. Гэтэл нөгөөдүүл нь тайлан тараагаад унавал яах вэ гээд ингээд ингээд ийм 2 аягүй тийм ээдрээтэй байгаа тул энэ аягүй зөв шийдэл гэж би харж байна. Ерөөсөө бүгдэд нь нээ. Гэхдээ тайланг нь бүгдэд нь хаа. Энэ чинь шударга байдал. Энэ чинь нөгөө тэгш эрх, тэгш гараа.

Ж.Бат-Эрдэнэ: Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Ажлын хэсгийн боловсруулж оруулж ирж байгаа энэ хуулийн томъёолол бол бас амаргүй л байдлаар л гарч байгаа л даа тэрийг ойлгож байна. Гэхдээ хууль бол нэг талдаа тодорхой субъектийн буюу тодорхой институтийн тэрийг төлөөлж байгаа эрх бүхий жишээ нь субъектийн тодорхой харилцаанд оролцох тэр үйл явцыг бүрэн зохицуулах ёстой. Тэгээд тэр үүднээс бол энэ Сонгуулийн тухай хуульд энэ заалт орсон гэж ойлгож байгаа. Энэ сонгуулийн тухай хуулийг сүүлд боловсронгуй болгохдоо бол сонгуулийн жил эхэлсэнтэй холбоотой бий болж байсан баахан жишээ нь төвөгтэй харилцаанууд байсан шүү дээ. Тэр нь саяын хэлсэн иргэдтэй уулзахаас гадна янз янзын юм тараадаг гээд энийг л цэгцлэх зорилгоор боловсронгуй болгосон хууль байхгүй юу. Тэгээд тэр дотор яасан гэхлээр зэрэг Улсын Их Хурлын гишүүний Үндсэн хуулиар болон Улсын Их Хурлаар олгогдсон чиг үүрэг буюу бүрэн эрхийг нь хэрэгжүүлэх боломжийг нь нээж өгсөн ийм л заалт байсан.

Тэгэхлээр зэрэг энэ заалт бол нэгэнтээ бид Үндсэн хууль зөрчсөн гээд Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гаргаад хүлээгээд авчихсан юм чинь бид тэрийг хэлэлцэхгүй гэдгээ ойлгож байгаа. Гэхдээ энийг бол саяын хэлсэн зүйлтэйгээ уясан байдлаар би дахиад бас харахгүй бол болохгүй байх. Яагаад гэвэл сонгуулийн жил эхлэх юм бол энэ чинь сүүлдээ бүр замбараагүй юм болох байдал руу орно. Тэр бодит байдал руу орно. Санал бодлоо илэрхийлэх, үзэл бодлоо илэрхийлэх, бусад хэлбэр нь нээлттэй. Энэ уулзалт гэдэг зүйлийг тухайн улс

төрчийн хувьд бол олгосон ямар нэгэн чиг үүрэгтэй нь уялдсан олгосон ийм эрх юм гэдэг дээр зохицуулсан учраас энийг ахиж хэдүүлээ жишээ нь дахиж ажлын хэсэг дээр хараад саяын та бүхний санал, бусад жишээ нь ажлын хэсэг дээр эрх зүйн хувьд нарийн судалгаанууд хийгдсэн байгаа байх. Тэрэнтэйгээ уясан байдлаар аливаа этгээд гэдэггүйгээр яаж жишээ нь боловсруулж болж байна гэдэг дээр санал гаргавал яасан юм бэ гэсэн ийм л би саналтай байгаад байгаа юм.

Тэгэхгүй бол дараа нь гарч болох үр дагаврыг бид одоо тооцож чадахгүй шүү дээ. Сонгуулийн жил эхлэх юм бол ямар нэгэн үр дагавар гарч байсан учраас Сонгуулийн хуулийг дахин боловсруулж хэлэлцүүлэх үедээ энийг чинь ингээд оруулчихсан заалт байсан байхгүй юу даа. Тэгэхээр энэ талаас нь ахиж харвал яасан юм бэ гэсэн ийм зүйлтэй байна. Тэрнээс иргэдийнхээ сонгох эрхийг, сонгогдох эрхийг хязгаарлах ийм зорилго бид агуулж болохгүй. Тийм зорилго ерөөсөө тавьж болохгүй. Тэрэнд бол та бүхэнтэй санал нэг байна.

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүн ажлын хэсгийн ахлагч.

Ц.Сандаг-Очир: Ямар ч гэсэн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал өөрөө хүлээж авсан нэгд. Энэ нь бид нарын баталсан хууль, Сонгуулийн хууль бол тэгш эрхийн зарчмыг алдагдуулсан байна, Улсын Их Хурлын гишүүнд давуу байдлыг олгосон байна гэдэг Үндсэн хуулийн цэцийн гол агуулга нь ерөөсөө энэ шүү дээ.

Тэгэхээр сая Баярмаа гишүүн үндсэндээ бараг яг цэцийн дүгнэлтийн агуулга болоод ажлын хэсгийн гол агуулгыг маш сайн зөв ойлгосон байна. Ерөөсөө уулзалт хийх эрх нь ч одоо мөрдөгдөж байгаа хуулиараа ч нээлттэй байгаа шүү дээ. Тэр битгий хэл 31-нээр төрийн албан тушаалтнууд, төрийн өмчийн компаниуд, сонгуульд нэр дэвших горилоч нар ажлаа өгч байгаад 1 сарын 1-нээс хойш нэр дэвшүүлэх ажиллагаа хүртэл хугацаанд орон нутгаар тойроод би дэвшинэ гэж ярихгүйгээр уулзалт, хурал, цуглаан хийгээд явах эрх нь нээлттэй байгаа байхгүй юу. Хориглосон юм байхгүй. Их Хурлын гишүүд баахан орон нутгаар тойрог томсгож байна гээд 1 сарын 1-нээс авхуулаад 4 сарын тэр нэр дэвшүүлэх ажиллагаа хүртэл хугацаанд баахан дагуулаад тойргуудаар явсан биз дээ өнгөрсөн хугацаанд? Энэ боломжууд одоогийн мөрдөж байгаа хуульд байгаа байхгүй юу. Энийг энэ хуулиар, энэ заалтаар хязгаарласан юм ерөөсөө байхгүй. Харин гагцхүү энэ сонгуулийн хуульд Улсын Их Хурлын гишүүний хэвлэмэл материал нь сонгогчдын саналыг татах зорилго юунд хамаарахгүй, Улсын Их Хурлын гишүүний хийсэн уулзалт нь энэ юунд хамаарахгүй гэж ингэж Улсын Их Хурлын гишүүнийг давуу байдал олгож ингээд байгаа нь өөрөө тэгш эрхийн зарчмыг алдагдуулаад байна л гэж байгаа байхгүй юу. Би ойлгож байна Их Хурлын гишүүдийн энэ өөрсөдтэй нь холбоотой, өөрсдийнх нь эрхийг хязгаарлах тэгш байх гэхээр ингээд жоохон өөрсдийнх нь асуудлыг хөндөхөөр ингээд жоохон ингээд шүүмжлэлтэй хандаад байгааг ойлгож байна.

Гэхдээ хэдүүлээ нийт том утгаараа эрэгтэй, эмэгтэй гэдэг юм уу, дарга, цэрэг хэн байхаас үл хамаараад уулзалт, хурал цуглаанаа нээлттэй яриад явъя. Гэхдээ гагцхүү тэр уулзалт, хурал, цуглаан бол сонгогчдын саналыг татах зорилго агуулаагүй уулзалт, хурал, цуглаан байх ёстой шүү. Материал юмаа бүгдээрээ больё хуулийн этгээд. Их Хурлын гишүүн нь ч больё, Засгийн газрын гишүүн нь ч, больё, орон нутгийн иргэдийн хурлын дарга, Засаг дарга нар нь ч больё, иргэн, тэр бизнес эрхлэгчид, нэр дэвшигч, бие даах нэр дэвшигч нар нь ч хэвлэмэл материал тараахгүй. Ингэвэл тэр төсвийн мөнгийг хэмнэх гээд байна. Маш олон сайд, Их Хурлын гишүүд энэ нэрийн доор төсвийн мөнгөөр олон гоё зурагтай, олон давхар

хуудастай тайлан сэтгүүлүүдийг тарааж давуу байдлыг олгоод байна. Энэний цаана дандаа төсвийн мөнгөөр голцуу хийгдэж байгаа. Энэ нь өөрөө давуу байдлыг бий болгож байна гэж ингэж л үзэж байгаа. Тийм учраас хэрвээ энэ батлагдаж чадвал уг нь их чухал заалт, зүйлд болох юм.

Тэрнээс одоо байгаа хориглочихсон байгаа зүйлийг нээж өгөх гээд, сонгуулийн сурталчилгааг уртасгах гээд байгаа зүйл ерөөсөө биш шүү.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийнхэн нэг зүйлийг хэлэхэд Улсын Их Хурлын гишүүний тайлангаа тавих хугацааг алга болгох гэлээ гээд чичрээд байгаа юм байхгүй шүү. Харин эсрэгээр тэрийг нь больчихъё гэж байгаа юм миний санаа. Больчихъё. Бүгдээрээ ижилхэн байя л даа гэж байгаа байхгүй юу. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт таны хэлж байгаа санаа бол бүх этгээд юу билээ, аливаа этгээд гэдгээрээ таны тэр төсвийн мөнгөөр унаа тэрэг явуулаад, унаа тэргээ дайчлаад ингээд явдаг зүйлийг хаах биш харин аливаа этгээд гэдгээрээ зүгээр бүдгэрүүлчхэж л байгаа байхгүй юу даа. Энийг чинь ар дээр явна шүү дээ. Адилхан л урьд өмнө яг тэр төсвийн мөнгө хэрэглээд байсан, унаа тэргээ ашиглаад ингээд явж байсан бол аливаа этгээд дотор чинь явах юм байгаа биз дээ? Явна шүү дээ. Энийг больж байгаа асуудал ерөөсөө биш байхгүй юу.

Харин зүгээр Улсын Их Хурлын гишүүн гэдгээсээ зугтчихаж байна харин. Зүгээр тэр үгийг нь алга болгоод л явдгаараа яв, улсын төсөв ашигладгаараа ашигла, татварын мөнгө ашигладгаараа ашигла гэдэг зүйлтэй аливаа этгээд гэдгээрээ зүгээр л зөвшөөрч байгаа, нэг гараараа хааж байгаа юм шиг харагдаад нөгөө гараа зөвшөөрчхөж байна шүү дээ. Үнэн биз дээ? Үнэн. Үгүй харин тэгвэл тэгээд больчихооч дээ яг тэр санаагаа хэлээд бүүр үнэхээр төсвийн мөнгө энээ тэрээ гэж байгаа бол сонгуулийн хугацаа эхлээд, сонгуулийн хугацаа эхэлж байгаа тухайн жилийн 1 сарын 1-нээсээ тэгвэл бүгдээрээ л явахаа больчихъё л доо. Тэртээ тэргүй сурталчилгааны хугацааг бид нар өгөөд байгаа шүү дээ. Тэн дээрээ л нэгмөсөн 1 гараанаас эхэлье л дээ.

Бүр хасчих л хэрэгтэй байсан юм. Үндсэн хуулийн цэцийн. Та нар замбараагүй юм ...болгочоод.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир танилцуулна. Дараагийн асуудалдаа орё.

13.00 цаг

“Сонгон шалгаруулах комисс байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тайлбарыг уншъя. Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2018 оны 10 дугаар тогтоолоор баталсан төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах журмын 4.1-д заасныг үндэслэн Төрийн албаны

зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах үүрэг бүхий комисс байгуулах.

Ингээд Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд танилцуулъя.

Төрийн албаны зөвлөлийн, төрийн албан хаагчийн төлөөлөл болох 2 гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.2-т зөвлөлийн гишүүнд Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тус бүр 1 хүний, төрийн албан хаагчийн төлөөлөл 2 хүний нэр дэвшүүлэх бөгөөд нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан төрийн туршлага, удирдлага, эдийн засаг, эрх зүй, боловсролын чиглэлээр мэргэшсэн, дээд боловсролтой, ял шийтгэл шийтгүүлж байгаагүй 45 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна.

Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо батална гэж заасан.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 10 дугаар тогтоолоор тогтоолын 1 дүгээр хавсралтын 41.1-д төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах комиссыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын алба, Төрийн албаны зөвлөлийн ажлын алба, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, Жендерийн үндэсний хорооны ажлын алба, Удирдлагын академи, Үндэсний аудитын газар, АТГ-аас төрийн албанд олон жил ажилласан удирдах албан тушаалтан 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр Төрийн байгуулалтын байнгын хорооны шийдвэрээр байгуулна гэж заасны дагуу Байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр тус комиссын бүрэлдэхүүнд нийт авахаар холбогдох байгууллагуудад албан бичиг явуулсан.

Үүний дагуу Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулж та бүхэнд танилцуулж байна.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбоотойгоор үг хэлэх гишүүд байна уу?

Алга байна.

13.05 цаг

Сандаг-Очир гишүүн горимын санал гаргая гэж байна. Сандаг-Очир гишүүний микрофон өгье.

Ц.Сандаг-Очир: Дарга саяын асуудалтай холбогдуулаад зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас.

Ж.Бат-Эрдэнэ: Саяын гэж яг ямар асуудал? Тэрийгээ хэлээрэй.

Ц.Сандаг-Очир: Цэцийн дүгнэлтийг хүлээж авсантай холбогдуулж ажлын хэсгээс оруулж ирсэн Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ажлын хэсгээ оруулсан заалтад зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас эцсийн хэлэлцүүлэгтэй хамт батлах горимын саналыг оруулж өгч танилцуулж байна. Санал гаргаж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүний гаргасан горимын саналтай холбоотойгоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад санал хураалтад 14-өөс 8 гишүүн оролцож, 57.1 хувиар санал дэмжигдлээ.

13.06 цаг

Хоёр дахь асуудалтай холбоотойгоор “Сонгон шалгаруулах комисс байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 14 гишүүнээс 9 гишүүн оролцож, 64.3 хувиар санал дэмжигдлээ.

“Сонгон шалгаруулах комисс байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

13.07 цаг

3.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганы хэлэлцүүлгээс хийх шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5.7-г та бүхэнд танилцуулъя.

Энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан.

Ингээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна. Санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатараас 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганы хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 14 гишүүнээс 8 гишүүн оролцож, 57.1 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлын хэлэлцэн шийдвэрлэлээ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг өндөрлөснийг мэдэгдье.

Баярлалаа гишүүддээ.

13.08 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР